

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилал: 73.040

Хагас коксон түлш. Техникийн шаардлага Semicoke. Technical requirements	MNS 5679-1 : 2011
--	-------------------

Стандартчиллын Үндэсний Зөвлөлийн 2011 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 46 дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэхүү стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1 Хамрах хүрээ

Энэхүү стандартаар хагас коксон түлшний техникийн шаардлагыг тогтооно.

2 Норматив ишлэл

Энэхүү стандартыг боловсруулахад дараах стандартуудыг иш татаж хэрэглэсэн болно. Эдгээр стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- 1/ MNS 894 : 2001 - Хүрэн ба чулуун нүүрс, антрацит, шатах занар, шахмал түлш - Хүлээн авах журам
- 2/ MNS 2732 : 2001 - Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Ашиглалтын дээж авах
- 3/ MNS 0669 : 1987 - Хатуу түлшийг шатаахад гарах илчлэгийн дээд хэмжээг тодорхойлох, илчлэгийн доод хэмжээг тооцоолох арга
- 4/ MNS ISO 562-2001 - Чулуун нүүрс ба кокс. Дэгдэмхий бодисын гарцыг тодорхойлох
- 5/ MNS 0652 : 1979 - Хүрэн чулуун нүүрс, антрацит, шатах занар. Үнслэг тодорхойлох арга
- 6/ MNS 0655 : 1979 - Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Чийглэг тодорхойлох арга.
- 7/ MNS 3903:1986 – Хатуу түлш. Нийт хүхрийн хэмжээг тодорхойлох .
- 8/ MNS 0893 : 2001 - Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Үзэгдэх чулуулаг ба жижгэрсэн ширхгийн агуулгыг тодорхойлох хяналтын дээжийг турших.

3 Нэр томьёо, тодорхойлолт

Энэхүү стандартад дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

3.1 Хагас коксон түлш

Нүүрсийг 500⁰-600⁰С-т халууны задралд оруулан боловсруулж гаргаж авсан утаагүй түлш бөгөөд ахуйн болон нийтийн халаалтын зориулалтаар хэрэглэгдэх түлш

4 Техникийн шаардлага

4.1 Хагас коксон түлшний техникийн шаардлага 1 дүгээр хүснэгтэд заасантай тохирч байна.

1 дүгээр хүснэгт

Түлшний нэр	Нийт чийглэг, W^t %, ихгүй	Дэгдэмхий бодисын гарц, V^{daf} %, ихгүй	Үнслэг, A^{ar} %, ихгүй	Нийт хүхэр, S_t^{ad} %, ихгүй	Илчлэг, Q_{gr} , багагүй, ккал/кг
Чулуун нүүрсний хагас коксон түлш	20	18	25	0.8	4800

Тайлбар: Дэгдэмхий бодисын гарцыг үнсгүй, хуурай төлөвт (daf); үнслэгийг ажлын төлөвт (ar), нийт хүхэр (ad), илчлэгийн хэмжээг агаарын хуурай төлөвт (Q_{gr}) тооцоноор илэрхийлнэ.

4.2 Хагас коксон түлшний бүхэллэгийн хэмжээ 80 мм –ээс ихгүй байна.

5 Шалгаж хүлээн авах, шинжлэх

5.1 Хагас коксон түлшийг хэрэглэгчид нийлүүлэхдээ энэхүү стандарт болон “Хүрэн ба чулуун нүүрс, антрацит, шатах занар, шахмал түлш - Хүлээн авах журам” MNS 894 : 2001 стандартыг баримтлана.

5.2 Хагас коксон түлшнээс дээж авах, шинжилгээ хийхдээ дараах стандартуудыг мөрдөнө. Үүнд:

1/ MNS 2732 : 2001 - Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Ашиглалтын дээж авах.

2/ MNS 0669 : 1987 - Хатуу түлшийг шатаахад гарах илчлэгийн дээд хэмжээг тодорхойлох, илчлэгийн доод хэмжээг тооцоолох арга.

3/ MNS ISO 562-2001 - Чулуун нүүрс ба кокс. Дэгдэмхий бодисын гарцыг тодорхойлох.

4/ MNS 0652 : 1979 - Хүрэн чулуун нүүрс, антрацит, шатах занар. Үнслэг тодорхойлох арга.

5/ MNS 0655 : 1979 - Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Чийглэг тодорхойлох арга.

6/ MNS 3903:1986 - Хатуу түлш. Нийт хүхрийн хэмжээг тодорхойлох .

7/ MNS 0893 : 2001- Хүрэн, чулуун нүүрс, антрацит, шатах занар. Үзэгдэх чулуулаг ба жижгэрсэн ширхгийн агуулгыг тодорхойлох хяналтын дээжийг турших.

6 Хадгалах, савлах, шошголох

6.1 Хагас коксон түлшийг зориулалтын битүү агуулах, байранд хадгална.

6.2 Хагас коксон түлшийг савлахдаа дараах мэдээлэл бүхий хэвлэмэл шошго наасан байна. Үүнд:

- улс, хотын нэр;
- үйлдвэрийн нэр;
- бүтээгдэхүүний нэр;
- жин (кг);
- үйлдвэрлэсэн огноо;
- энэ стандартын дугаар;
- хадгалах, хэрэглэх болон аюулгүй ажиллагааны зааварчилгаа

6.3 Хагас коксон түлшийг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагатай нийцсэн хэмжээтэйгээр савлах буюу задгайгаар нийлүүлж болно. Хэмжээг хэрэглэгч ба нийлүүлэгч нар харилцан тохиролцоно.

ТӨГСӨВ.